

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН ДАРГЫН
БАТАЛСАН ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТАД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2025 оны 05 дугаар сарын 13

Улаанбаатар хот

Д/д	Тушаалыг			Актын утга	Улсын нэгдсэн бүртгэлийн дугаар	Захиргааны хэм хэмжээний актын		
	Баталсан албан тушаалтан	Огноо	№			Хэрэгжилт	Үнэлгээ	Санал
1	Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газар	2010.12.08	№А/396	Журам батлах тухай “Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлэх хүсэлт гаргасан гадаадын иргэнтэй ярилцлага хийх тухай журам”-ыг нэгдүгээр, ярилцлага хийх комиссын бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар	3224	Үндэслэл: Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5.2-д “Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлэх хүсэлт гаргасан гадаадын иргэнтэй ярилцлага хийх журмыг батлах”, Гэр бүлийн тухай хуулийн 58 дугаар зүйл. Хэрэгжилт: Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 3224 дугаарт бүртгэгдэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.	Эрх зүйн үндэслэл хүчин төгөлдөр хэвээр байгаа бөгөөд Гэр бүлийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.4-д “Гадаадын иргэн Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авсныг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 111 дүгээр зүйлд заасан байгууллага бүртгэнэ” гэж заасан ч Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд дээрх зүйл, заалт байхгүй болно. Байгууллагын даргын 2012 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн А/619 дүгээр тушаалаар нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд	Гэр бүлийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.4-д “Гадаадын иргэн Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авсныг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 111 дүгээр зүйлд заасан байгууллага бүртгэнэ” гэж заасан ч Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд дээрх зүйл, заалт байхгүй тул Гэр бүлийн тухай хуульд өөрчлөлт оруулах саналтай.

							хөдөлгөөн хийгдсэн.	
2	Гадаадын иргэн, харьяатын газар	2023.12.19	№А/476	Жагсаалт шинэчлэн батлах тухай “Монгол Улсын иргэний харьяаллын асуудлыг шийдвэрлэхэд шаардагдах бичиг баримтын жагсаалт”-ыг нэгдүгээр, Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргагчийн мэдүүлгийн хуудасны загварыг хоёрдугаар, Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргагчийн мэдүүлгийн хуудасны загварыг гуравдугаар, Монгол Улсын харьяатаас гарах хүсэлт гаргагчийн мэдүүлгийн хуудасны загварыг дөрөвдүгээр хавсралтаар	6536	Үндэслэл: Харьяатын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 6-д “Монгол Улсын иргэний харьяаллын асуудлыг шийдвэрлэхэд шаардагдах бичиг баримтын жагсаалтыг гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тогтооно”. Хэрэгжилт: Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 6536 дугаарт бүртгэгдэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.	Эрх зүйн үндэслэл хүчин төгөлдөр хэвээр байна. Энэхүү журам нь бусад эрх зүйн зохицуулалттай зөрчилдсөн асуудал үүсээгүй байна.	Уг актад өөрчлөлт, хөдөлгөөн хийх шаардлагагүй, цаашид хэвээр мөрдөн ажиллах.
3	Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар	2016.06.10	№А/284	Журам батлах тухай “Гадаадын иргэнд Монгол Улсад хувийн хэргээр зорчих урилга олгох журмыг нэгдүгээр, Монгол Улсад хувийн хэргээр зорчих урилгын загварыг хоёрдугаар хавсралтаар”	3648	Үндэслэл: Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5.4 дэх хэсэг “гадаадын иргэнд Монгол Улсад хувийн хэргээр зорчих урилга олгох журмыг батлах”. Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 3648 дугаарт	Эрх зүйн үндэслэл хүчин төгөлдөр хэвээр байна. Энэхүү журам нь бусад эрх зүйн зохицуулалттай зөрчилдсөн асуудал үүсээгүй байна. Тухайн актын эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд өөрчлөлт хөдөлгөөн хийгдэж	“Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй шийдвэрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнгийн тайлан, хуулиар тусгайлан эрх олгосон заалтын судалгааны дүн, цаашид авах арга хэмжээний тухай” Засгийн газрын

						бүртгэгдэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.	байгаагүй болно.	хуралдааны 2023 оны 48 дугаар тэмдэглэлийг
4	Гадаадын иргэн, харьяатын газар	2017.03.14	№А/111	Журам батлах тухай “Гадаадын иргэнийг Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлэх, гарахыг түдгэлзүүлэхийг хүчингүй болгох тухай шийдвэр гаргах, түүнийг хэрэгжүүлэх журам”	3710	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5.3 дахь хэсэг “Гадаадын иргэнийг Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлэх, гарахыг түдгэлзүүлэхийг хүчингүй болгох тухай шийдвэр гаргах, түүнийг хэрэгжүүлэх журмыг батлах”. Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 3710 дугаарт бүртгэгдэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.	Эрх зүйн үндэслэл хүчин төгөлдөр хэвээр байна. Энэхүү журам нь бусад эрх зүйн зохицуулалттай зөрчилдсөн асуудал үүсээгүй байна. Байгууллагын даргын 2021 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А/184 дүгээр тушаалаар нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд хөдөлгөөн хийгдсэн.	үндэслэн энэхүү 2 журмаар зохицуулсан харилцааг хуульд тусгах, хуулиар эрх олгосон заалтыг хүчингүй болгох хүрээнд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан 2024 оны 01/339 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж байсан. Засгийн газрын хуралдааны 2023 оны 48 дугаар тэмдэглэлийн 4 дэх заалтын хүрээнд, салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, тоог багасгах зорилгоор Засгийн газар болон Хууль зүй, дотоод хэргийн яаманд ажлын хэсэг, дэд ажлын хэсгүүд байгуулагдан

								ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд бэлтгэл болон суурь судалгааны ажлыг хангах, дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн А/357 дугаар тушаалаар байгуулсан. Тус ажлын хэсэг нь хариуцсан салбарын яамдаас мэргэжил арга зүйн зөвлөгөө, дэмжлэг авч, харилцан ажиллан “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж байна.
--	--	--	--	--	--	--	--	--

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН БАТАЛСАН ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ
АКТАД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2025 оны 05 дугаар сарын 13

Улаанбаатар хот

Д/д	Тушаалыг			Актын утга	Улсын нэгдсэн бүртгэлийн дугаар	Захиргааны хэм хэмжээний актын		
	Баталсан албан тушаалтан	Огноо	№			Хэрэгжилт	Үнэлгээ	Санал
1	ХЗДХС/ НХХС	2001.04.11	№100, 32	Журам батлах тухай “Гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх журам”	1733	Үндэслэл:Гэр бүлийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.7 дахь хэсэг “Гадаадын иргэнд хүүхэд үрчлүүлэх журмыг хууль зүйн болон эрүүл мэнд, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүд хамтран тогтооно”. Хэрэгжилт:Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 1733 дугаарт бүртгэгдэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.	Эрх олгосон эрх зүйн үндэслэл хүчин төгөлдөр хэвээр байна. Энэхүү журам нь бусад эрх зүйн зохицуулалттай зөрчилдсөн асуудал үүсээгүй байна. Тухайн актын эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд өөрчлөлт хөдөлгөөн хийгдэж байгаагүй болно.	Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгагдсан.
2	ХЗС	2014.06.09	A/90	Заавар батлах тухай Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний хяналтын улсын байцаагч “Тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх, тусгай хэрэгслийг хадгалах заавар”-ыг нэгдүгээр, “Тусгай хэрэгслийн	3454	Үндэслэл:Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.12 дахь хэсэг нь 2023 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар дугаарлалтад нь өөрчлөлт орж, үндэслэл хэсэг нь тус хуулийн 41.13 дахь хэсэг “Тусгай хэрэгслийн жагсаалт, хэрэглэх, хадгалах зааврыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн	Зааврын 1.1, 3.3, 4.1 дэх хэсэгт эшлэл болгосон Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсгийн дугаарлалтад нь 41.10 болж өөрчлөлт орсон, зааврын 3.1 дэх хэсэгт эшлэл хийсэн Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.10 дахь	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар зааврын үндэслэл болгосон, эшлэл хийсэн заалтуудын дугаарлалтад нь өөрчлөлт орсон тул зааварт нэмэлт, өөрчлөлт оруулах саналтай.

				жагсаалт"-ыг хоёрдугаар хавсралтаар		батална" гэж өөрчлөгдсөн. Хэрэгжилт:Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 3454 дугаарт бүртгэгдэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.	хэсэг нь 41.11 болж өөрчлөлт орсон байна. Энэхүү заавар нь бусад эрх зүйн зохицуулалттай зөрчилдсөн асуудал үүсээгүй байна. Тухайн актын эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд өөрчлөлт хөдөлгөөн хийгдэж байгаагүй болно.	
3	ХЗДХС	2011.03.21	№52	Журам батлах тухай "Барьцаа гаргуулах, буцаан олгох, барьцааны хэмжээг тогтоох журам"	3232	Үндэслэл:Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.4-д "энэ хуулийн 36.5-д заасан барьцаа гаргах, буцаан олгох, барьцааны хэмжээ тогтоох журмыг батлах; Хэрэгжилт:Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 3232 дугаарт бүртгэгдэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.	Эрх зүйн үндэслэл хүчин төгөлдөр хэвээр байна. Энэхүү журам нь бусад эрх зүйн зохицуулалттай зөрчилдсөн асуудал үүсээгүй байна. Тухайн актын эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд өөрчлөлт хөдөлгөөн хийгдэж байгаагүй болно.	Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй шийдвэрт хяналт- шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнгийн тайлан, хуулиар тусгайлан эрх олгосон заалтын судалгааны дүн, цаашид авах арга хэмжээний тухай" Засгийн газрын хуралдааны 2023 оны 48 дугаар тэмдэглэлийг
4	ХЗДХС	2023.03.31	A/120	Журам шинэчлэн батлах тухай "Гадаадын иргэнд Монгол Улсад оршин суух, харьяалалгүй хүнд зорчих үнэмлэх олгох, хэвлэх болон тэдгээрийг	6195	Үндэслэл:Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.1 дэх хэсэг "Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух, харьяалалгүй хүн зорчих үнэмлэхийн загвар, тэдгээрийг олгох, хэвлэх болон эзэмших, хадгалах, ашиглах журмыг батлах".	Эрх зүйн үндэслэл хүчин төгөлдөр хэвээр байна. Энэхүү журам нь бусад эрх зүйн зохицуулалттай зөрчилдсөн асуудал үүсээгүй байна.	үндэслэн энэхүү 3 журмаар зохицуулсан харилцааг хуульд тусгах, хуулиар эрх олгосон заалтыг хүчингүй болгох хүрээнд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн

				эзэмших, хадгалах, ашиглах журам"-ыг шинэчлэн батлах тухай		Хэрэгжилт:Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 6195 дугаарт бүртгэгдэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.		шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан 2024 оны 01/339 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж байсан.
5	ХЗДХС	2022.01.17	A/08	Журам батлах тухай “Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газарт Монгол Улсад үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох, үйл ажиллагаанд нь хяналт тавих журам”	5684	Үндэслэл:Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.5 дахь хэсэг “энэ хуулийн 40.1.5-д заасан олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газарт Монгол Улсад үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох, үйл ажиллагаанд нь хяналт тавих журам батлах”. Хэрэгжилт:Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 5684 дугаарт бүртгэгдэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.	Эрх зүйн үндэслэл хүчин төгөлдөр хэвээр байна. Энэхүү журам нь бусад эрх зүйн зохицуулалттай зөрчилдсөн асуудал үүсээгүй байна. Тухайн актын эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд өөрчлөлт хөдөлгөөн хийгдэж байгаагүй болно.	Засгийн газрын хуралдааны 2023 оны 48 дугаар тэмдэглэлийн 4 дэх заалтын хүрээнд, салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, тоог багасгах зорилгоор Засгийн газар болон Хууль зүй, дотоод хэргийн яаманд ажлын хэсэг, дэд ажлын хэсгүүд байгуулагдан ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд бэлтгэл болон суурь судалгааны ажлыг хангах, дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн А/357

								дугаар тушаалаар байгуулсан. Тус ажлын хэсэг нь хариуцсан салбарын яамдаас мэргэжил арга зүйн зөвлөгөө, дэмжлэг авч, харилцан ажиллан “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж байна.
--	--	--	--	--	--	--	--	--

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР